



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 09 дугаар сарын 11

Дугаар 18/04

Баян-Өндөр сум

Аймгийн далбааны эх загвар,  
тодорхойлолт, өнгөний кодыг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн далбааны эх загварыг нэгдүгээр, түүний тодорхойлолтыг хоёрдугаар, өнгөний кодыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 74 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА




Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Ээлжит бус XVIII хуралдааны 18/04 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**ОРХОН АЙМГИЙН ДАЛБААНЫ ЭХ ЗАГВАР**



## ОРХОН АЙМГИЙН ДАЛБААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Орхон аймгийн далбаа нь номин ногоон өнгөтэй 1:2-ын хэмжээтэй байна. (1:2 гэдэг нь далбааны өргөн, уртын харьцаа буюу далбааны урт нь өргөнөөс 2 дахин их байх) Далбааны ишин талын гол хэсэгт Орхон аймаг, Эрдэнэт хотын бэлгэ тэмдгийг байрлуулсан, суурь дэвсгэр номин ногоон өнгийг Хүн төрөлхтөн эртнээс хүчирхэг байдал, итгэл найдвар, энх амгалан, баян чинээлэг, мөнхийн бэлгэдэл болгон үзсээр ирсэн. Түүнчлэн энэ өнгийг сэтгэл зүй судлалд амгалан тайван байдлыг бэлэгдэж, тайвшруулах өнгө гэж үздэг. Мөн оюу номин эрдэнийн өнгө бөгөөд Эрдэнэтийн овооны эрдэс баялгийг бэлэгдсэн байна.

Орхон аймаг, Эрдэнэт хотын логоны тухайд:

Орхон аймаг, Эрдэнэт хот нь Монгол Улсын хоймор хэсэгт байрласныг билэгдэж, дээд талд нь “Эрдэнэт” гэдэг үгийг бичсэн бөгөөд Орхон аймаг, Эрдэнэт хотын баялгийг билэгдэж фоныг нь зэсийн өнгөөр зурсан байна.

Гэрийн хоймор авдартаа Эрдэнэт уулын эрдэнэ баялгийг агуулсан гэдэг утга санааг агуулж дөрвөн хүчтэний нэг арсланг зурсан. Мөн хэл амнаас хамгаалж хүч чадалтай байхыг билэгдсэн.

Арсланд чандмань бариулж, чандмань нь Орхон аймаг, Эрдэнэт хотын өнгөрсөн, одоо, ирээдүйг билэгдэхээс гадна оройн хэсгийг гурван өнгөөр ялгасан нь дараах утга санааг агуулж байна. Үүнд:

Ногоон өнгө нь газар, хөгжил дэвшил дэлгэрч дээдлэхийн бэлэгдэл

Улаан өнгө нь Монголчууд эртнээс улаан өнгийг халуун дотно, баяр баясгалангийн өнгө, баатарлаг сүр жавхааг билэгдсэн, гал халуун сэтгэл, галын дөл, мандах улаан нарыг билэгдсэн

Хөх өнгө нь мөнх тэнгэр, мөнхөд үргэлжлэх, мөнхөд орших санааг илтгэсэн

Тойруулан зурсан цэнхэр хадаг нь Орхон аймаг, Эрдэнэт хотын хүн зон олон эд баялгаа түшээд үргэлж сайн сайхан, аз жаргалтай амьдраасай гэсэн санааг агуулсан байна.

Чандмань эрдэнэ нь Эрдэнэт хотын бэлэгдлийг төлөөлнө.

Чандмань эрдэнийн гурван өнгө нь оюу эрдэнэ, тана эрдэнэ, зэс эрдэнийг билэгдэх бөгөөд, нар. - сар, гал, найрамдал нөхөрлөлийг илэрхийлсэн, дүрсний шар өнгө нь алтан эрдэний далбааны суурь хөх цэнхэр өнгө нь ган эрдэнийг илэрхийлнэ. Ингэснээрээ хүндэтгэл, бэлэгдлийн зүйлс нь 5-аас доошгүй эрдэнийг багтаадаг Монгол уламжлалыг хадгалсан юм.

Далбаа нь Орхончууд өнө мөнхөд энх амгалан, өнөр баян амьдрахын өлзий бэлэгдэл болно.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн Ээлжит бус XVIII хуралдааны 18/04 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



ОРХОН АЙМГИЙН ДАЛБАА, БЭЛГЭ ТЭМДЭГ БОЛОХ АРСЛАН НЬ ДАРААХ ӨНГӨНИЙ КОДТОЙ БАЙНА

1. Далбааны суурь өнгө номин ногоон өнгөний код :

C: 77

M: 1

Y: 36

K: 0

2. Орхон аймаг, Эрдэнэт хотын бэлгэ тэмдэг болох Арслангийн өнгөний код :

R: 254	G: 2	L: 50
O: 276	M: 8	A: 4
E: 9	Y: 100	B: 87
#992200	K: 0	
H: 52	H: 33	Y: 209
S: 100	L: 50	E: 145
B: 100	S: 100	G: 81



R: 1	L: 70	L: 7
S: 76	M: 12	A: 7
B: 104	S: 48	B: 71
#A020F0	K: 0	
H: 100	H: 100	Y: 71
S: 76	L: 7	E: 14
B: 104	S: 100	G: 52

R: 14	C: 54	L: 7
G: 10	M: 76	A: 6
B: 18	Y: 40	B: 73
#B0E133	K: 0	
H: 232	H: 232	Y: 21
S: 71	L: 11	E: 98
B: 20	S: 17	G: 104

R: 203	G: 19	L: 81
G: 233	M: 6	A: 3
B: 249	Y: 2	B: 10
#C0E0F4	K: 0	
H: 100	H: 107	Y: 208
S: 76	L: 67	E: 89
B: 96	S: 63	G: 99

R: 279	G: 7	L: 47
G: 6	M: 83	A: 70
B: 0	Y: 83	B: 61
#908080	K: 2	
H: 2	H: 2	Y: 71
S: 100	L: 43	E: 94
B: 96	S: 30	G: 57